

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 06 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Бизнес регистр
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ
12. БНХАУ-ын нүүрсний зах зээл



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны 4 дүгээр сар)

6.1 хувь

Үндэсний статистикийн хороо
туршилтын тооцоо

Валютын нөөц

(2024 оны 6 дугаар сар)

4,839 сая \$

Инфляц

(2024 оны 6 дугаар сар)

5.1 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 6 дугаар сар)

1.3 их наяд ₮

Экспорт

(2024 оны 6 дугаар сар)

7,886 сая \$

Импорт

(2024 оны 6 дугаар сар)

5,378 сая \$

ГШХО

(2024 оны 1 дүгээр улирал)

885 сая \$

Зээлийн хүү

(2024 оны 5 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 1 дүгээр улирал)

1.3 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны
тувшин 60 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2023 оны 4 дүгээр улирал)

16.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны 2 дугаар улирал)

99.1 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах
үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 1 дүгээр улирал)


19.8 хувь



2024 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 7.8 хувь байсан бол эхний 4 сарын байдлаар 6.1 хувь байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Өмнөх оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн салбарын оролцоо багасаж, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Тайлбар: 2024.3 сарын туршилт тооцоо

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 оны 1 дүгээр улирал)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний улиралд **7.8 хувиар өслөө.**

- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 13.1 хувиар тэлж өсөлтийн 1.9 хувийг, ХАА-н салбар 31.4 хувиар буурч өсөлтийг -1.3 хувиар хязгаарлалаа.

- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 8.5 хувиар өсөж өсөлтийн 0.9 нэгж хувийг;

- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 7.7 хувиар өсөж өсөлтийн 4.1 хувийг ;

- Бүтээгдэхүүний цэвэр татвар 13.1 хувиар өсөж өсөлтийн 2.1 хувийг бүрдүүлсэн байна.

- Үйлчилгээний салбар болон цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Мөн боловсруулах, барилгын салбарын үйлдвэрлэл өсөлттэй байв.

- Харин том малын зүй бус хоргодол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний улиралд 13.1 хувиар тэллээ.

- Газрын тос, молибдений баяжмал, алтны олборлолтоос бусад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө.

- ХАА-н салбар 2024 оны эхний 3 сард 31.4 хувиар агшлаа.


- Том малын зүй бус хоргодол 2024 оны 1 дүгээр улиралд 6.3 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдлээ. Энэ нь оны эхний нийт малын 9.8 хувийг эзэлснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурч байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 16 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж байгаа бол хөнгөн болон хүнд үйлдвэрлэл боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 12.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.7 их наяд буюу 16 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 18 хувиар нэмэгдээд байна.
- Хөнгөн болон хүнд үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 11 хувиар өслөө.

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол

- Тус салбарын бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2024 оны эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8 хувиар өсөөд байна. Үүнд:
- Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл 16.4 хувиар өсөж, бодит өсөлтийн 10.0 нэгж хувийг бүрдүүлэв.
- Харин боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбаруудын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс тус тус 2.4 хувь, 0.7 хувь, 13.5 хувиар өссөн байна.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


(голлох бүтээгдэхүүнээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны эхний 5 сард 39 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 59 хувиар өсөв.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 5 хувиар өсөж 612 мянган тоннд хүрсэн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар, цар тахлын өмнөх үеэс 71.9 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:

- Хүнсний бүтээгдэхүүн 12.5 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 11.4 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 9.5 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:


- Арьс, арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 1.9 хувиар,
- Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийнх 2.8 хувиар тус тус буурулаа.



Дотоод эрэлт идэвхжиж, эдийн засгийн өсөлт эрчимжив.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эрэлтээс тооцсон ДНБ 2024 оны эхний улиралд 7.8 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 23.4 нэгж хувийн, хөрөнгийн хуримтлал 3.8 нэгж хувийн тус тус зэрэг нөлөө, цэвэр экспорт 19.4 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 47.1 хувиар өсөж, нийт эрэлтийг дэмжиж байна.
- Өрхийн бодит орлого 19.8 хувиар сайжирсан нь нийт өрхийн хэрэглээг дэмжиж, өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар тэлэв.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал 5.4 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 6.3 сая толгойд хүрсэн нь эдийн засагдах үндсэн хөрөнгийн хуримтлал буурахад голлон нөлөөллөө.

- Үйлчилгээний экспортын орлого өмнөх оны мөн үеэс багасаж, нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурав.
- Бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөхөд барааны импорт 24.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




2024 оны эхний 6 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 13,2 тэрбум ам.доллар, тэнцэл 2.5 тэрбум ам долларын ашигтай гарлаа.

ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 оны эхний 6 сард 7,852 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 60 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 4,675 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өслөө.
- Зэсийн баямалын экспортын орлого 1,454 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 356 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 292 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар өслөө.

- 2024 оны эхний 6 сард импорт 5,378 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 21 хувиар өссөн байна.
- Нийт импортын 19.1 хувийг тоног төхөөрөмж, 18.8 хувийг нефть, 8.7 хувийг автомашин эзэлж байна.


- Тоног төхөөрөмжийн импорт 840 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44.8 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 826 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 383 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 52.4 хувиар өслөө.



2024 оны эхний 6 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян. баррель,)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 эхний 6 сард 39.4 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар өслөө.
- Гашуунсхайт боомтоор 20.3 сая тонн, Шивээхүрэн боомтоор 11.8 сая тонн, Ханги боомтоор 1.8 сая тонн, бусад боомтуудаар 5.5 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.





- Зэсийн баяжмалын экспорт 2024 эхний 6 сард 782 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувиар өслөө.
- Гашуунсхайт (Оюу-Толгой) боомтоор 487 мянган тонн, Замын-Үүд (Эрдэнэт) боомтоор 298 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.

- Төмрийн хүдрийн экспорт 2024 эхний 6 сард 3,596 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.4 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 3,233 мянган тонн, Бургастай боомтоор 322 мянган тонн, бусад боомтуудаар 41 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.

- Газрын тосны экспорт 2024 оны эхний 6 сард 2,065 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 1,894 мянган баррель, Замын-Үүд боомтоор 171 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.



2024 оны эхний 6 сарын байдлаар сарын голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.



- Малын махны экспорт 2024 оны эхний 6 сард 20,510 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 52 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 6,615 мянган тоннд хүрлээ.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 6 сард 52,538 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар буурлаа.

- Ноолуурын экспорт 2024 оны эхний 6 сард 2,687 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.

- Ноосны экспорт 2024 оны эхний 6 сард 111 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА




[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоо

НҮҮРС


(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 6 сарын дундаж үнэ 251 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өссөн байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 250 ам.доллар, 2025 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 6 сарын дундажар 9,642 ам.доллар болж, өмнөх оны мөн 13 хувиар өссөн байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 8,800 ам.доллар, 2025 онд 9,000 ам.долларт хүрэхээр байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 4 сарын дундаж үнэ 107 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 5 хувиар буурсан байна.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 онд 120 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

- Брент газрын тосны 2024 оны эхний 6 сарын дундаж үнэ 82 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 13 хувиар өслөө.
- Олон улсын шинжээчдийн таамаглалаар 2024 оны дундаж үнэ 85 ам.доллар, 2025 оны дундаж үнэ 80 ам.долларт хүрэхээр байна.



МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ҮНИЙН ХАНДЛАГА




[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоос

НҮҮРС


(\$/тонн, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Хил үнэ)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Чулуун нүүрсний 2024 оны 6 дугаар сарын хилийн дундаж үнэ 108 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 18 хувиар буурсан байна.

- Зэсийн баяжмалын хилийн үнэ 2024 оны 6 дугаар сарын дундажаар 2,086 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн байна.

- Төмрийн хүдрийн 2024 оны 6 дугаар сарын дундаж үнэ 90 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн байна.


- Газрын тосны 2024 оны 6 дугаар сарын дундаж үнэ 80 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 13 хувиар өссөн байна.



2024 оны эхний 5 сарын байдлаар УУББ-ээр нийт 28 сая тонн нүүрс болон 1.5 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 29 сая тонн нүүрс арилжсан.
- 2024 оны 6 дугаар сарын байдлаар 2024 онд 14.5 сая тонн нүүрс арилжиж, 1.8 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 6 дугаар сард 3.9 сая тонн нүүрс борлуулсан бол 6 дугаар сард 1.2 сая тонн нүүрс борлууллаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 6 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 111 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 99 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 52 ам.доллар, дээд үнэ 172 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 6 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 1.7 сая тонн төмрийн хүдэр арилжсан.
- 2024 оны 6 дугаар сарын байдлаар 2024 онд 996 мянган тонн төмрийг арилжаалж, 72 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 6 дугаар сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 69 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 6 дугаар сард хэлцлийн доод үнэ 56 ам.доллар, дээд үнэ 90 ам.долларт хүрэв.

4.2 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА - Компаниар 2024.06 сар



2024 ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН НИЙТ АРИЛЖАА



[PowerBi report](#)
Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоо

юанаарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.

НИЙТ НҮҮРС		
14,553.6	\$1,733,190	188
мян. тонн	мян. \$	арилжаа

НИЙТ ТӨМӨР		
980.1	\$71,449	148
мян. тонн	мян. \$	арилжаа

НИЙТ ЗЭСИЙН БАЯЖМАЛ		
5.4	\$11,984	2
мян. тонн	мян. \$	арилжаа

НҮҮРС		
"Эрдэнэс Тавантолгой" ХК		
10,777.6	\$1,243,096	27
мян. тонн	мян. \$	арилжаа

ТӨМРИЙН БАЯЖМАЛ		
"Монголросцветмет" ТӨҮГ		
181.5	\$17,244	25
мян. тонн	мян. \$	арилжаа

ЗЭСИЙН БАЯЖМАЛ		
"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ		
5.4	\$11,984	2
мян. тонн	мян. \$	арилжаа

"Тавантолгой" ХК		
627.2	\$88,714	5
мян. тонн	мян. \$	арилжаа

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК		
387.5	\$25,613	51
мян. тонн	мян. \$	арилжаа

НИЙТ ЖОНШ		
4.4	\$1,568	1
мян. тонн	мян. \$	арилжаа

"Энержи Ресурс" ХХК		
3,065.6	\$390,948	151
мян. тонн	мян. \$	арилжаа

ТӨМРИЙН ХҮДЭР		
"Монголросцветмет" ТӨҮГ		
313.5	\$22,829	58
мян. тонн	мян. \$	арилжаа

ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖМАЛ		
"Монголросцветмет" ТӨҮГ		
4.4	\$1,568	1
мян. тонн	мян. \$	арилжаа

"Хангад Эксплорэйшн" ХХК		
51.2	\$6,962	4
мян. тонн	мян. \$	арилжаа

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК		
97.7	\$5,763	14
мян. тонн	мян. \$	арилжаа

"Монгол алт" (МАК) ХХК		
32.0	\$3,471	1
мян. тонн	мян. \$	арилжаа

4.3 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА – Үнийн өсөлт 2024.06 сар






2024 ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН
НИЙТ АРИЛЖАА



[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоо


юанаарх үнийг ам.доллар луу шилжүүлэв.






2024 оны эхний 5 сарын байдлаар төлбөрийн тэнцэл 351 сая ам.долларын ашигтай гарлаа. Харин Монголбанк 2024 оны 6 дугаар сард юанийн своп хэлцлийн төлбөрийг төлсөнтэй холбоотойгоор гадаад валютын улсын нөөц өмнөх сараас 345 сая ам.доллараар буурлаа.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 5 сард 351 сая ам.долларын ашигтай гарч, ашиг өмнөх оны мөн үеэс 153 сая ам.доллараар буурлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.4 тэрбум ам.доллараар нэмэгдсэн ч импортын өсөлт 1.1 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 5 сард 964 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 376 сая ам.доллараар өссөн байна.

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 6 дугаар сарын эцэст 4,839 сая ам.доллар болж, өмнөх сараас 345 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 1 тэрбум ам.доллараар буюу 26.7 хувиар тус тус өслөө.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 6 дугаар сард өдөрт дунджаар 0.02 төгрөгөөр чангарч, сарын эцэст 3,381 болж, оны эхнээс 29 төгрөгөөр буюу 0.9 хувиар чангарлаа.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



- Төв банк 2024 оны эхний 6 сард нийт 3,071 сая ам.долларыг зах зээлд нийлүүлээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 84.0 хувиар буюу 1,402 сая ам.доллараар өндөр дүн юм.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2024 оны 6 дугаар сард 5.1 хувьд хүрлээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 5.1 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 1.8 нэгж хувь (35.3%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 3.3 нэгж хувь буюу 64.7 хувийг эзэлж байна.

- 2024 оны 6 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.3 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөхөд хүнсний бүлэг 41 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 14 хувь, бусад бараа, үйлчилгээ 13 хувиар тус тус нөлөөлжээ.
- Сарын инфляцад мах, махан бүтээгдэхүүн 17 хувь, талх, гурил, будаа 3 хувь, хүнсний ногоо 32 хувийг бүрдүүлж байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 6 дугаар сард суурь инфляц 5.2 хувь гарч, нийт инфляцын 3.5 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 10 сар дараалан буурч байна.


- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 6 дугаар сард жилийн инфляцын 10 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурлаа.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 6 дугаар сарын байдлаар 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өссөн нь голлон нөлөөллөө.


ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)




ТӨСВИЙН ОРЛОГО

(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД

(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)




- Нэгдсэн төсөв 2024 оны 6 дугаар сард 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 260 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар буурсан байна.
- Орлого 2024 оны 6 дугаар сард 14.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 35.2 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 1.7 их наяд төгрөг буюу 67.2 хувиар, АМНАТ 88.8 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар, НӨАТ 594.6 тэрбум төгрөг буюу 27.3 хувиар, нийгмийн даатгалын орлого 309.7 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.
- Зарлага 2024 оны 6 дугаар сард 12.9 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3.9 их наяд төгрөг буюу 42.9 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, аллагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлээд байна.
- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 29.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 33.7 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 31.7 хувьд хүрч, өмнөх сараас 3.6 нэгж хувиар өслөө. Төгрөгийн харилцах, хадгаламж, гадаад валютын харилцах өсөлттэй байсан бөгөөд гадаад валютын хадгаламж буурлаа. Зээлийн хүү 5 дугаар сард өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрлээ.


МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 6 дугаар сарын эцэст 41.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 31.7 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 16.6 нэгж хувийг, гадаад валютын харилцах 5.8 нэгж хувийг, төгрөгийн харилцах 10.5 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж -1.9 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.


ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Нийт хадгаламж 24.2 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 19.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 36.2 хувиар, өмнөх сараас 4.0 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буурсан бөгөөд өмнөх сараас 5.3 хувиар өслөө.


ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монгол банк

- Банкнудын зээлийн үлдэгдэл 2024 оны 5 дугаар сарын эцэст 31.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 6.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)




Эх сурвалж: Монгол банк

- Банкнудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 16.9 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрлээ.
- Банкнудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 11.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө.




Цар тахлын улмаас буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр өсөж, ажиллагчдын тоо 1.3 саяд хүрлээ.


АЖИЛЧДЫН ТОО, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн, хувь)




АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



- Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 182.3 мянгаар нэмэгдэж, 1,293.6 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 150.5 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 1 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 129.2 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 53.2 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 59.4 хувь болж өссөн ч цар тахлын өмнөх үеэс 0.7 хувиар өндөр байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 5.6 мянган хүнээр буурч, 71 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурч, 5.2 хувьд хүрлээ.

- Ажилчдын тоо 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.3 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.8 мянган хүнээр нэмэгдлээ.
- Ажилчдын тооны өсөлтөд, үйлчилгээ ба бусад, худалдаа, тээвэр, барилга, уул уурхай, боловсруулах, ус, цахилгааны салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.

- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсөж, 2,235 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.3 дахин өндөр байна.




ААН-ийн бодит борлуулалт 2024 оны 5 дугаар сарын байдлаар 8.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 48.6 хувиар өслөө. Борлуулалт өсөлтийн 33.6 нэгж хувийг худалдааны салбар бүрдүүлээ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААН-ИЙН ӨСӨЛТ (нэгж хувь, бүтцээр)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО (мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ (тэрбум, 2015 оны үнээр)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТЫН ӨСӨЛТ (2024 оны 05 дугаар сар)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

- 2024 оны II улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд 99.1 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өслөө.
- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 2.4 мянгаар, тэр дундаа бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 1.1 мянгаар нэмэгдсэн байна (Үйлчилгээний салбар нийт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн 76 хувийг бүрдүүлж байна).

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 4 хувиар буурч 246 мянгад хүрлээ. Үүнд, үйл ажиллагааг түр зогссон ААН-ийн тоо буурсан нөлөөллөө. Харин үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо өсөлтөө хадгалж байна.
- ААН-ийн үйл ажиллагаа илүү идэвхжиж, нийт бүртгэлтэй ААН-д үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн эзлэх хэмжээ сүүлийн 5 жилийн дээд түвшин буюу 40 хувьд хүрлээ /2021-2023 онуудад 37 хувь байсан/.

- 2024 оны 5 дугаар сард ААН-ийн бодит борлуулалтын орлого 8.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 48.6 хувиар өслөө.

- ААН-ийн борлуулалтын орлого эрчим хүч болон уул уурхайгаас бусад салбарт ААН-ийн борлуулалт өслөө.
- Борлуулалтын орлогын өсөлтийн 33.6 нэгж хувийг худалдаа, 8.2 нэгж хувийг хөдөө аж ахуй, 6.3 нэгж хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна.



Худалдааны салбар ААН-ийн бодит борлуулалтын 56.3 хувийг дангаараа бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 59.7 хувиар өсөв.

ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ
(салбараар, тэрбум, 2015 оны үнээр)




- 2024 оны 5 дугаар сарын байдлаар худалдааны салбар ААН-ийн бодит борлуулалтын 56.3 хувийг дангаараа бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалт 59.7 хувиар өсөв.
- Худалдааны салбарын араас үйлчилгээ (17.0%), хөдөө аж ахуй (8.4%) салбарууд борлуулалтад эзлэх хэмжээгээр удаах байранд орж, бодит борлуулалтын өсөлтийн 14.5 нэгж хувийг бүрдүүлсэн байна.

ААН-ИЙН БОДИТ БОРЛУУЛАЛТ
(салбараар, тэрбум, 2015 оны үнээр)




- 2024 оны 5 дугаар сарын байдлаар уул уурхайн салбарын бодит борлуулалтын цар тахлын өмнөх түвшинд хүрэхгүй байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурсан байна.

ААН-ИЙН НЭРЛЭСЭН БОРЛУУЛАЛТ
(тэрбум)



- 2024 оны 5 дугаар сарын байдлаар нэрлэсэн үнээрх аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 16.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 41 хувиар өсжээ.




ААН-ИЙН ХЭВЛЭСЭН НӨАТ-ЫН БАРИМТЫН ТОО (сая)



- ААН-ийн хэвлэсэн НӨАТ-ын баримтын тоо 2024 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеүдээс дээд түвшинд хүрлээ.
- Үүнд, санхүү, даатгалын салбарын хэвлэсэн баримтын тоо огцом нэмэгдсэн нь нөлөөлжээ.



ОХУ-ын Төв банк мөнгөний бодлогын хүүг 16 хувьд хадгалсан хэвээр байгаа бөгөөд инфляц аажмаар өсөж, зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.



- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны 1 дүгээр улиралд 5.4 хувиар өслөө.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой эдийн засаг 2022 оны 1 дүгээр улирлаас хойш өсөлтэй хэвээр байна.


- Экспорт 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсөж, 2022 оны 10 дугаар сараас хойш хамгийн өндөр өсөлтөд хүрлээ.
- Экспортын өсөлтийг газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна.
- Импорт 2024 оны өмнөх оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар буурсан байна.
- Импортын бууралтад мөнгөний хатуу бодлого гол нөлөөлөл үзүүлсэн байна.

- Инфляцын түвшин 2024 оны 5 дугаар сард нэг жилийн дээд түвшин болох өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсөж, 8.3 хувьд хүрлээ.
- Инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, Төв банкны зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байна.

- Аж үйлдвэрийн салбарын PMI индекс 2024 оны 5 дугаар сард 54.4 болж, өмнөх сарын үзүүлэлтээс 0.9 нэгжээр өсөж, тэллээ.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт өмнөх сард үйлдвэрлэл, уул уурхайн салбарын өсөлт удааширсантай холбоотой өмнөх сараас 0.1 нэгжээр буурч, 3.9 нэгжид хүрлээ.



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.7 хувь болж, өсөлтийн хурд өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар саарлаа. 2024 оны 6 дугаар сард аж үйлдвэрийн гарц, жижиглэнгийн худалдааны өсөлтийн хурд саарч, инфляц өмнөх сараас буурлаа.



- БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.7 хувь болж, өсөлтийн хурд өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар буурлаа.
- Экспорт 2024 оны 6 дугаар сард өмнөх оноос 8.6 хувиар өссөн нь 2023 оны 4 дүгээр сараас хойших хамгийн өндөр өсөлт боллоо.
- Импорт 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар агшлаа.

- 2024 оны 6 дугаар сард аж үйлдвэрийн гарцын өсөлт 5.3 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар саарсан бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 1.7 нэгж хувиар буурч, 2.0 хувьд хүрлээ.

- Хэрэглээний үнийн индекс сүүлийн 5 сар дараалан өсөж, 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өслөө.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2024 оны 6 дугаар сард -0.8 хувьд хүрч, 21 сар дараалан буурлаа.


- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 6 дугаар сард 49.5 болж, өмнөх сарын түвшинд хэвээр байв.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас мөн өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.

Тус индекс нь богино хугацааны идэвхжлийг илэрхийлэх бөгөөд ААН-үдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



Австрали улсын сайн чанарын коксжих нүүрсний хоригийг цуцалсантай холбоотойгоор БНХАУ-ын Австрали улсаас худалдан авч буй коксжих нүүрсний биет хэмжээ 3 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдлээ.


НҮҮРСНИЙ ИМПОРТ (улсаар, сая тонн)



Эх сурвалж: GACC

- БНХАУ-ын нүүрсний импорт 2024 оны 5 дугаар сард 44 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар өслөө.
- 2024 оны 5 дугаар сард Индонези улсаас худалдан авч буй нүүрс өнгөрсөн оны мөн үеэс 8 хувиар буурч, харин Монгол улсаас худалдан авч буй нүүрс өнгөрсөн оны мөн үеэс 37 хувиар, Австрали улсаас худалдан авч буй нүүрс өнгөрсөн оны мөн үеэс 19 хувиар тус тус өслөө.


ЭХНИЙ 5 САРЫН НҮҮРСНИЙ ИМПОРТ (топ 5 улсаар, сая тонн)



Эх сурвалж: GACC

- БНХАУ-ын нүүрсний импорт 2024 оны эхний 5 сард 205 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11 хувиар өслөө.
- БНХАУ нүүрс худалдан авах орнуудын тоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд бусад улсаас худалдан авах нүүрсний хэмжээ 2024 оны эхний 5 сард 17 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 80 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн, Индонези болон ОХУ-аас худалдан авах нүүрсний биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс буурлаа.


КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ (төрлөөр, сая тонн)



Эх сурвалж: GACC

- БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2024 оны 5 дугаар сард 10 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар өслөө.
- 2024 оны 5 дугаар сард Австрали улсаас худалдан авч буй коксжих нүүрс өнгөрсөн оны мөн үеэс 64 хувиар буурч, харин Монгол улсаас худалдан авч буй коксжих нүүрс өнгөрсөн оны мөн үеэс 37 хувиар өслөө.

ЭХНИЙ 5 САРЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ (топ 5 улсаар, сая тонн)



Эх сурвалж: GACC


- БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2024 оны эхний 5 сард 48 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар өслөө.
- Австрали улсын коксжих нүүрсний хоригийг цуцалсантай холбоотойгоор Австрали улсаас худалдан авч буй коксжих нүүрсний биет хэмжээ 3 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдлээ.

Тэмдэглэл. Тус мэдээлэл нь нэг сарын хугацаанд хоёрч гардаг болно.




БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд 2024 оны 2 дугаар улиралд зорилтод түвшинд хүрээгүй, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байгаа зэрэг нь БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээ буурах шалтгаан болж байна.

КОКСЖИХ НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭ
(сая тонн)




- БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээ 2024 оны эхний 5 сард 238 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2 хувиар буурлаа.
- БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд 2024 оны 2 дугаар улиралд зорилтод түвшинд хүрээгүй, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байгаа нь БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээ буурах шалтгаан болж байна.

КОКСЖИХ НҮҮРСНИЙ ҮЙЛВЭРЛЭЛ
(сая тонн)




- БНХАУ-ын коксжих нүүрсний үйлдвэрлэл 2024 оны эхний 5 сард 187 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11 хувиар буурлаа.
- БНХАУ-ын Шанси муж дахь коксжих нүүрсний уурхайн хяналт шалгалт үргэлжилж байгаа нь дотоодын коксжих нүүрсний үйлдвэрлэлийг удаашруулж байна.

КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ
(сая тонн)



- БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2024 оны 2 дугаар сард 48 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар өслөө.
- БНХАУ-ын коксжих нүүрсний үйлдвэрлэлийн бууралт хэрэглээний бууралтаас өндөр түвшинд байгаагаас шалтгаалан коксжих нүүрсний импорт нэмэгдэж байна.

КОКСЖИХ НҮҮРСНИЙ НӨӨЦ
(сая тонн)



- БНХАУ-ын коксжих нүүрсний нөөц 2024 оны 2 дугаар сард 17 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар буурлаа.

Тэмдэглэл. Тус мэдээлэл нь нэг сарын хугацаанд хоёрч гардаг болно.



БНХАУ-ЫН ГОЛЛОХ БООМТУУДЫН НҮҮРСНИЙ ҮНЭ



[PowerBi report](#)

Дэлгэрэнгүй өдрийн мэдээг харах QR код, холбоос

ГАНЦМОД БООМТООР НЭВТЭРЧ БҮЙ НҮҮРСНИЙ ҮНЭ

(\$/тонн)




Эх сурвалж: GACC

- Ганцмод боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй баяжуулсан коксжих нүүрсний үнэ 189 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 13 хувиар өслөө
- Ганцмод боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй коксжих нүүрсний үнэ 157 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар өслөө

СЭХЭЭ БООМТООР НЭВТЭРЧ БҮЙ НҮҮРСНИЙ ҮНЭ

(\$/тонн)



Эх сурвалж: GACC

- Сэхээ боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй баяжуулсан 1/3 коксжих нүүрсний үнэ 116 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Сэхээ боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй 1/3 коксжих нүүрсний үнэ 93 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.
- Сэхээ боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй хуурай 1/3 коксжих нүүрсний үнэ 124 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.

ЖИНТАН БООМТООР НЭВТЭРЧ БҮЙ НҮҮРСНИЙ ҮНЭ

(\$/тонн)



Эх сурвалж: GACC

- Жинтан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй Австралийн коксжих нүүрсний үнэ 260 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 19 хувиар өслөө.
- Жинтан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй АНУ-ын коксжих нүүрсний үнэ 245 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18 хувиар өслөө.
- Жинтан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй Шанси мужийн коксжих нүүрсний үнэ 248 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 18 хувиар өслөө.

ТИАНЖИН БООМТООР НЭВТЭРЧ БҮЙ НҮҮРСНИЙ ҮНЭ

(\$/тонн)



Эх сурвалж: GACC

- Тианжан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй Австралийн коксжих нүүрсний үнэ 295 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Тианжан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй АНУ-ын коксжих нүүрсний үнэ 267 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 19 хувиар өслөө.
- Тианжан боомтоор 6 дугаар сард нэвтэрч буй ОХУ-ын коксжих нүүрсний үнэ 269 ам долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16 хувиар өслөө.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ